

# ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

“Хөвсгөл барилга захиалагчийн хяналтын төв” ОНӨҮГ-ийн 2024 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд хийсэн санхүүгийн аудитын тайлан.

Аудитын код: ХӨА-2025/006/НА-СТА-ОНӨҮГ

Цахим хуудас:  
[www.audit.mn](http://www.audit.mn)

Хөвсгөл аймаг  
2025 он

Дарга, тэргүүлэх аудитор: А.Эрдэнэбаатар

Утас: 88883317 Цахим хаяг: [erdenebaatara@audit.gov.mn](mailto:erdenebaatara@audit.gov.mn)

Аудитын менежер: Б.Тэгшдэлгэр

Утас: 99089116 Цахим хаяг: [tegshdelgerb@audit.gov.mn](mailto:tegshdelgerb@audit.gov.mn)

Ахлах аудитор: Б.Давааням

Утас: 92113932 Цахим хаяг: [davaanyam@audit.gov.mn](mailto:davaanyam@audit.gov.mn)

Гурван Хөх Морьт Аудит ХХК

Гүйцэтгэх захирал: Н.Отгончимэг

Утас: 99051815 Цахим хаяг: [gurvankhukhmoritllc@gmail.com](mailto:gurvankhukhmoritllc@gmail.com)

Аудитор: Ш.Саранчимэг

Утас: 99834361 Цахим хаяг: [gurvankhukhmoritllc@gmail.com](mailto:gurvankhukhmoritllc@gmail.com)

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## АГУУЛГА

---

1. Хараат бус аудиторын дүгнэлт .....	3-4
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан .....	5
3. Санхүүгийн тайлангийн тодруулга.....	5-8
3.1 Компани, түүний үйл ажиллагаа .....	9
3.2 Компанийн гадаад, дотоод орчин.....	9-10
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	10
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого ба толилуулгад гарсан өөрчлөлт .....	10-15
4. Аудитын тайлан .....	15
4.1 Ерөнхий зүйл .....	15
4.2 Материаллаг байдал .....	15
4.3 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .....	17
4.4 Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилт .....	15
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....	1-18
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	18
5. Аудитын илрүүлэлт .....	18-20
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл .....	21

**Товчилсон үгийн жагсаалт**

СТОУС	Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ТЗБАХ	Техник Зохион Байгуулалтын Арга Хэмжээ
ТӨХК	Төрийн Өмчит Хувьцаат Компани



## ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

АЗДТГ-ын байр, А корпус 3 давхар,  
Мөрөн сум, Хөвсгөл аймаг, 67120  
Утас/факс: 7038 3793, Цахим шуудан: khuvsgul@audit.gov.mn  
Цахим хуудас: www.audit.mn

2025.03.14 № 1/295  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

“БАРИЛГА ЗАХИАЛАГЧИЙН  
ХЯНАЛТЫН ТӨВ” ОНӨҮГ-ИЙН  
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ  
Д.БАТЧУЛУУН ТАНАА

### Хараат бус аудиторын дүгнэлт

#### Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу “Хөвсгөл барилга захиалагчийн хяналтын төв” ОНӨҮГ -ийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна

#### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

#### Асуудлыг онцолсон хэсэг

Тайлант онд улс, орон нутгийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих 79 төсөл арга хэмжээнд захиалагчийн хяналтыг хэрэгжүүлэн ажилласан байна.

#### Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Аудитаар нягтлан бодох бүртгэл тайлагналтай холбоотой 130,760.3 мянган төгрөгийн алдааг аудитын явцад залруулж, орлого бүрдүүлэлт, өр төлбөр, бүртгэл тайлагналтай холбоотой 82,644.5 мянган төгрөгийн зөрчилд 2 зөвлөмж хүргүүлээ.

#### Бусад асуудлын хэсэг

Хөвсгөл барилга захиалагчийн хяналтын төв” ОНӨҮГ нь тайлант жилд батлагдсан орлогын төлөвлөгөөг 86.9 хувийн гүйцэтгэлтэй ба зардлын гүйцэтгэл 77.8 хувийн гүйцэтгэлтэй байна.

#### Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

870002091

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  А.ЭРДЭНЭБААТАР



## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Төгрөгөөр

Мөрийн дугаар	Балансын зүйл	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1.1.1	Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгө	18,324,038.49	63,488,644.26
1.1.6	Бараа материал	10,560,152.00	11,434,882.79
1.1.11	<b>Эргэлтийн хөрөнгийн дүн</b>	<b>28,884,190.49</b>	<b>74,923,527.05</b>
1.2.1	Үндсэн хөрөнгө	96,143,424.78	100,495,824.70
1.2.2	Биет бус хөрөнгө	1,254,000.00	1,204,500.00
1.2.10	<b>Эргэлтийн бус хөрөнгийн дүн</b>	<b>97,397,424.78</b>	<b>101,700,324.70</b>
1.3	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>126,281,615.27</b>	<b>176,623,851.75</b>
2.1.1.1	Дансны өглөг	3,185,357.41	15,026,011.72
2.1.1.2	Цалингийн өглөг	2,470,240.53	6,162,977.75
2.1.1.13	<b>Богино хугацаат өр төлбөрийн дүн</b>	<b>5,655,597.94</b>	<b>21,188,989.47</b>
2.2	<b>Өр төлбөрийн нийт дүн</b>	<b>5,655,597.94</b>	<b>21,188,989.47</b>
2.3.1	Төрийн өмч	11,500,000.00	11,500,000.00
2.3.9	Хуримтлагдсан ашиг	109,126,017.33	143,934,862.28
2.3.11	<b>Эздийн өмчийн дүн</b>	<b>120,626,017.33</b>	<b>155,434,862.28</b>
2.4	<b>ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ</b>	<b>126,281,615.27</b>	<b>176,623,851.75</b>

### 2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

Төгрөгөөр

Мөрийн дугаар	Үзүүлэлт	Өмнөх оны дүн	Тайлант жилийн дүн
1	<b>Борлуулалтын орлого ( цэвэр )</b>	<b>284,097,456.36</b>	<b>407,705,746.10</b>
3	<b>Нийт ашиг ( алдагдал )</b>	<b>284,097,456.36</b>	<b>407,705,746.10</b>
8	Бусад орлого	284,097,456.36	407,705,746.10
12	Бусад зардал	287,015,771.33	370,343,346.15
18	<b>Татвар төлөхийн өмнөх ашиг ( алдагдал )</b>	<b>(2,918,314.97)</b>	<b>37,362,399.95</b>
20	<b>Татварын дараах ашиг ( алдагдал )</b>	<b>(2,918,314.97)</b>	<b>37,362,399.95</b>
23.3	Эргэж төлөгдөх зээл	1,654,873.00	2,553,555.00
24	<b>Орлогын нийт дүн</b>	<b>(4,573,187.97)</b>	<b>34,808,844.95</b>
25	<b>Нэгж хувьцаанд ноогдох суурь ашиг ( алдагдал )</b>	<b>0.00</b>	<b>0.00</b>

### 2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

Төгрөгөөр

Үзүүлэлт	Өмч	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
<b>2023 оны 01-р сарын 01-ээрх үлдэгдэл</b>	<b>11,500,000.00</b>	<b>113,699,205.31</b>	<b>125,199,205.31</b>
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт		(24,498,058.65)	(24,498,058.65)
Залруулсан үлдэгдэл	11,500,000.00	89,201,146.66	100,701,146.66
Тайлант үеийн цэвэр ашиг ( алдагдал )	0.00	(4,573,187.97)	(4,573,187.97)
<b>2023 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл</b>	<b>11,500,000.00</b>	<b>109,126,017.33</b>	<b>120,626,017.33</b>
Тайлант үеийн цэвэр ашиг ( алдагдал )	0.00	34,808,844.95	34,808,844.95
2024 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	11,500,000.00	143,934,862.28	155,434,862.28

Хөвсгөл аймгийн “Барилга захиалагчийн хяналтын төв” ОНӨҮГ-ийн ийн 2024 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Төгрөгөөр

Мөрийн дугаар	Үзүүлэлт	Өмнөх оны дүн	Тайлант жилийн дүн
<b>1.1</b>	<b>Мөнгөн орлогын дүн (+)</b>	<b>284,097,456.36</b>	<b>392,479,546.10</b>
1.1.1	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	284,097,456.36	392,479,546.10
1.2.1	Ажиллагчдад төлсөн	179,436,137.71	212,287,619.22
1.2.2	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	18,034,935.40	22,183,295.04
1.2.3	Бараа материал худалдан авахад төлсөн	14,443,665.40	11,707,752.88
1.2.4	Ашиглалтын зардалд төлсөн	7,175,600.00	8,212,618.80
1.2.5	Түлш, шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	14,000,000.00	13,545,454.54
1.2.7	Татварын байгууллагад төлсөн		20,635,412.30
	Даатгалын төлбөрт төлсөн	1,774,681.00	
1.2.9	Бусад мөнгөн зарлага	28,337,395.00	54,869,232.55
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	20,895,041.85	49,038,160.77
2.2	Мөнгөн зарлагын дүн (-)	1,320,000.00	1,320,000.00
2.2.1	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	1,320,000.00	1,320,000.00
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	1,320,000.00	1,320,000.00
3.2.1	Дамжуулан зээлдүүлэх зээлээс эргэж төлөгдөх	(1,654,873.00)	0.00
3.2.2	Эргэж төлөгдөх зээл		2,553,555.00
3.3	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(1,654,873.00)	2,553,555.00
4	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	17,920,168.85	45,164,605.77
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	1,445,834.88	18,324,038.49
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	18,324,038.49	63,488,644.26

2.5 Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

Төгрөгөөр

№	ҮЗҮҮЛЭЛТ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү
<b>1</b>	<b>Нийт орлогын дүн</b>	453,935,168.0	392,479,546.1	61,455,621.9
	<i>Борлуулалтын орлого</i>	453,935,168.0	392,479,546.1	61,455,621.9
1	Үндсэн ба нэмэгдэл цалин	210,012,500.0	198,939,816.2	11,072,683.8
2	Урамшуулал цалин	35,377,834.0	17,604,400.0	10,971,344.0
	<b>НИЙТ ЦАЛИН</b>	245,390,334.0	216,544,216.2	28,846,127.8
3	Нийгмийн даатгал /Ажил олгогч/	28,575,744.0	21,619,435.2	6,956,308.9
4	Албан томилолтын зардал	59,750,000.0	37,738,400.0	22,011,600.0
5	Байр ашиглалтын зардал /түрээс, ашиглалтын зардал/	9,250,668.0	8,212,618.8	1,038,049.2
6	Бичиг хэрэг	3,033,200.0	1,154,150.9	1,879,049.1
7	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,755,800.0	861,800.0	894,000.0
8	Шуудан, харилцаа холбооны зардал	3,180,000.0	1,419,749.4	1,760,250.6
9	Тээвэр, шатахууны зардал	21,908,627.0	13,680,909.2	8,227,717.8
10	Урсгал засвар /багаж техник хэрэгсэл /	497,000.0	142,000.0	355,000.0
11	Урсгал засвар /автомашин /	4,274,000.0	5,932,672.7	(1,658,672.7)
12	Бусдаар гүйцэтгүүлэх ажил, үйлчилгээ	4,410,000.0	2,423,000.0	1,987,000.0
13	Автомашин татвар, үзлэг оношилгоо	547,608.0	111,477.0	436,131.0
14	Мэдээлэл технологийн үйлчилгээ	1,850,000.0	1,724,904.0	125,096.0
15	Сургалтын зардал	5,970,000.0	1,076,454.6	(4,893,545.4)
16	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	9,840,000.0	9,740,000.0	100,000.0
17	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	4,980,000.0	-	4,980,000.0
18	Тавилга эд хогшил	750,000.0	-	750,000.0

**Хөвсгөл аймгийн “Барилга захиалагчийн хяналтын төв” ОНӨҮГ-ийн ийн 2024 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан**

19	Компьютер техник хэрэгсэл худалдан авах	4,399,800.0	1,320,000.0	3,079,800.0
20	багаж техник хэрэгсэл худалдан авах	5,895,000.0		5,895,000.0
21	Үндсэн хөрөнгийн элэгдлийн зардал		12,243,300.0	(12,243,300.0)
22	Банкны үйлчилгээний зардал		48,000.0	(48,000.0)
23	Эргэж төлөгдөх зээл		2,553,555.0	(2,553,555.0)
	Зардлын дүн	416,257,781.0	338,546,643.0	(77,711,148.0)
<b>3</b>	<b>АШИГ АЛДАГДАЛ</b>	<b>521,335.0</b>		
2	НӨАТ	52,133		
<b>4</b>	<b>НИЙТ АШИГ, АЛДАГДАЛ</b>	<b>469,201.0</b>		

### 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

#### 3.1 Компанийн үйл ажиллагаа, зорилго зорилтын талаар

“Хөвсгөл Барилга Захиалагчийн Хяналтын төв” ОНӨҮГ-ын эрхэм зорилго нь “Хөвсгөл аймгийн хэмжээнд Захиалагч, Гүйцэтгэгч, Ашиглагчийн мэргэшсэн зөвлөх нь байж хариуцлагатай, чадварлаг гүйцэтгэгчийг төлөвшүүлэхэд оршино” гэсэн байна. Дэвшүүлсэн зорилт:

1. Барилгын норм ба дүрэм бусад дүрэм заавар, техникийн нөхцөл, даалгаврыг хангасан мэргэжлийн экспертээр батлагдсан Ажлын зураг, техникийн даалгавраар ажил гүйцэтгэж хэвшүүлэх;
2. Гүйцэтгэгчийн ажлын талбай, гүйцэтгэлийн зохион байгуулалтыг Барилгын тухай хууль, бусад дүрэм, стандартын дагуу зохион байгуулж хэвшүүлэх;
3. Гүйцэтгэлийн акт протокол, бичиг баримтыг үе шатны ажлын тухай бүрд баталгаажуулж хэвшүүлэх;
4. Барилга угсралтад хэрэглэгдэж байгаа материал, хэрэгсэл, тоног төхөөрөмжийн лабораторийн туршилт шалгалтыг чанаржуулах, нэр төрлийг олшруулах, чанартай баталгаатай материал хэрэгслээр барилга угсралтыг гүйцэтгүүлэх;
5. Гүйцэтгэгчийн ажлын талбай дээрх хөдөлмөрийн сахилга бат, аюулгүй ажиллагааг чанд мөрдүүлж мэргэжлийн чадварлаг ажилтан бүхий гүйцэтгэгч ажиллахыг шаардах ба чадварлаг гүйцэтгэгчийг төлөвшүүлэх гэжээ.

“Хөвсгөл Барилга Захиалагчийн Хяналтын төв” ОНӨҮГ нь Хөвсгөл аймагт баригдаж байгаа барилга угсралтын ажлын үе шат бүрд захиалагчийн хяналтыг хэрэгжүүлж, чанартай, баталгаатай барилга байгууламжийг улсын комисст хүлээлгэн өгөх үндсэн зорилготойгоор захиалагчийг төлөөлөн гүйцэтгэгчээр Барилгын норм ба дүрэм, техникийн даалгавар, баталгаажсан ажлыг зургийн дагуу гүйцэтгэхэд зөвлөгөө өгөх, хяналт тавих ажлуудыг гүйцэтгэдэг байна. Байгууллагын онцлог давуу талууд:

- Мэргэшсэн зөвлөх үйлчилгээний баг мэргэжлийн техник хяналтын зөвлөх үйлчилгээ үзүүлдэг.
- Барилга угсралтын ажил эхлүүлэх, ашиглалтад оруулах хүртэлх үйл ажиллагаанд гүйцэтгэгчидтэй тулж ажиллан Захиалагчийн хяналтыг холбогдох хууль дүрэм, баталгаажсан ажлын зургийн дагуу хэрэгжүүлдэг;
- Хяналтын үр дүнд үндэслэн Газрын харилцаа, Барилга хот байгуулалтын газарт ашиглалтад оруулахад бэлэн болсон барилга байгууламжийг хүлээлгэн өгөх, улсын комисс ажиллуулах;
- Хяналтын үйл явцын талаарх мэдээлэл болон ажлын гүйцэтгэлийн талаарх мэдээллийг холбогдох алба хэлтэст тодорхой хугацаанд мэдээлж гүйцэтгэгчийн гэрээнд заасан графикийн дагуу санхүүжилтийг олгох дүгнэлтийг гаргаж тайлагнаж байх;
- Шаардлагатай үед Мэргэжлийн хяналтын байгууллагад хандан төрийн захиргааны байгууллагын хяналт хийлгэх, туршилт сорьцын шинжилгээ хийлгэх, барилга байгууламж дээр дүгнэлт гаргуулах хүсэлт илгээж хамтран ажиллах гэх мэт онцлог давуу талтай байна.

#### 3.2 Компанийн гадаад, дотоод орчин.

Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй хууль эрх зүйн орчны талаар:

## Хөвсгөл аймгийн “Барилга захиалагчийн хяналтын төв” ОНӨҮГ-ийн 2024 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

Хөвсгөл Барилга Захиалагчийн Хяналтын Төв ОНӨҮГ нь байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааны чиглэлд Монгол улсын хууль тогтоомж, тогтоол шийдвэрийг мөрдөн Дэд шатны удирдах байгууллага болох ИТХ, аймгийн Засаг дарга, БХБЯ, Барилга хөгжлийн төвийн шийдвэрийг тусган ажилладаг. Дэд бүтэц хяналтын нэгж нь Барилгын тухай хууль, Барилгын норм дүрэм, Захиалагчийн хяналтын тухай журам, ХАБЭА тухай хууль хэргэлдэг, захиргааны нэгж нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Компанийн тухай хууль, Аж ахуй нэгжийн орлогын албан татварын тухай хууль, Нэмүү өртгийн албан татварын тухай хууль, Хувь хүний орлогын албан татварын тухай хууль, Нийгмийн даатгалын шимтгэлийн тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль зэргүүдийг мөрдөн ажилласан байна. Шалгагдагч байгууллага нь Хөдөлмөрийн дотоод журам, дотоод албан томилолтын журмыг мөрдөж ажилладаг байна.

Хөвсгөл Барилга захиалагчийн хяналтын төв” ОНӨҮГ -ийн гүйцэтгэх захирал нь орон нутгийн өмчит үйлдвэрийн газрын үйлдвэрлэлийн үндсэн үйл ажиллагаа, үйлчилгээ, борлуулалт, эдийн засгийн үр ашиг, хөрөнгийн өгөөжийг өмнөх онд төлөвлөсөн хэмжээнээс дээшлүүлэх зорилгоор Хөвсгөл аймгийн засаг даргатай 2024 оны үйл ажиллагаандаа баримтлан ажиллахаар онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээ байгуулан ажилласан байна.

### **Байгууллагын дотоод хяналтын талаар:**

Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоолоор баталсан Аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах нийтлэг журам”-ийн дагуу Хөвсгөл барилга захиалагчийн хяналтын төв-ийн гүйцэтгэх захирлын 2023 оны 09 дүгээр сарын 09-ны өдрийн 96 дугаар тушаалаар дотоод хяналтын ажлын хэсгийг байгуулан 2024 оны 05 дугаар сарын 27-ны өдрийн А/32 дугаар тушаалаар ажлын хэсгийн бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулсан байна.

Тайлант онд тус байгууллагын дотоод хяналтын нэгж нь дараах чиглэлээр дотоод хяналтыг хөрөнгийн тооллого, цагийн бүртгэл, байгууллагын үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлтэд улирлаар хяналтыг хэрэгжүүлэн ажилласан байна.

Хяналтаар илэрсэн зөрчил дутагдлыг тухай бүр нь арилгаж ажиллах зөвлөмжүүдийг өгч хэрэгжилтийг тооцож ажилласан байна.

Санхүүгийн үйл ажиллагаанд дотоод хяналтын нэг, хоёрдугаар үе шатны тогтолцоо бий болсон байна гэж үзлээ.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Дотоод аудиторын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд тусалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### **3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал**

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлд заасан иж бүрдийн дагуу толилуулсан байна гэж үзлээ.

Хөвсгөл Барилга захиалагчийн хяналтын төв ОНӨҮГ нь 2024 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан дахь зарим ажил гүйлгээг аккруз сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэж Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлд заасан иж бүрдийн дагуу толилуулсан байна гэж үзлээ.

**Байгууллагын мөрдөж буй нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийн талаар:**

Хөвсгөл аймгийн “Барилга захиалагчийн хяналтын төв” ОНӨҮГ-ийн ийн 2024 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

Санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаандаа “Хөвсгөл барилга захиалагчийн хяналтын төв” ОНӨҮГ-ын даргын 2022 оны 05 дугаар сарын 24-ны өдрийн А/68 дугаар тушаалаар баталсан “Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг”-ийг үйл ажиллагаандаа ашиглаж байна.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого ба толилуулгад орсон өөрчлөлт

“Хөвсгөл барилга захиалагчийн хяналтын төв” ОНӨҮГ -ын 2024 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2017 оны 361 дүгээр тушаалаар баталсан аж ахуйн нэгжид мөрдөгдөх “Санхүүгийн тайлан, тодруулгыг бэлтгэх заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн гол бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 50,342.2 мянган төгрөгөөр буюу 39,8 хувиар өссөн байна.

#### Хүснэгт №-1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/мянган төгрөгөөр/ Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	18,324.0	63,488.6	45,164.6
Бараа материал	10,560.1	11,434.8	874.7
Үндсэн хөрөнгө	97,397.4	101,700.3	4,302.9
<b>Нийт хөрөнгө</b>	<b>126,281.6</b>	<b>176,623.8</b>	<b>50,342.2</b>
Өр төлбөр	5,655.6	21,188.9	15,533.4
Эздийн өмчийн дүн	11,500.0	11,500.0	-
Хуримтлагдсан ашиг	109,126.0	143,934.8	34,808.8
<b>Өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	<b>126,281.6</b>	<b>176,623.8</b>	<b>50,342.2</b>

Хүснэгтээс харахад мөнгөн хөрөнгө 45,164.6 мянган төгрөгөөр, бараа материал 874.7 мянган төгрөгөөр, үндсэн хөрөнгө 4,302.8 мянган төгрөгөөр тус тус нэмэгдсэн байна.

Мөнгөн хөрөнгийн үлдэгдэлд банкин дахь мөнгөн хөрөнгө 63,488.6 мянган төгрөг байна.

Бараа материалын дансанд 24,372.7 мянган төгрөгийн материалыг худалдан авч, 23,488.8 мянган төгрөгийн материалыг зарцуулжээ.

Үндсэн хөрөнгийн дансанд 1,320.0 мянган төгрөгийн хөрөнгө худалдан авч бүртгэсэн, машин тоног төхөөрөмжийн дансанд бүртгэлтэй 25,377.0 төгрөгийн өртөгтэй ашиглалтын хугацаа дууссан элэгдлийн зардлаараа өөрийн өртгийг нөхсөн хөрөнгийг 15,226.2 мянган төгрөгөөр дахин үнэлж ашиглалтын хугацааг 2 жилээр нэмэгдүүлсэн байна.

Аудитаар дараах зөрчил илэрсэн байна.

Илрүүлэлт: Өр төлбөр өмнөх оноос 15,533.4 мянган төгрөгөөр өссөн үзүүлэлтэй байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8. "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 71 дүгээр зүйлийн 71.8 "өр, авлагыг барагдуулах арга хэмжээ авч үлдэгдлийг тооцсон байх" гэсэн заалт болон "Эрх ба үүрэг" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Зөвлөмж өгөх

### 3.5 Зорилтот түвшний төлөвлөгөө, гүйцэтгэл

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 3, 20 дугаар зүйлийн 20.1.3-д заасны дагуу Гүйцэтгэх захирал нь үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө /техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний төлөвлөгөөг боловсруулж, зохих байгууллагаар батлуулж, биелэлтийг хангах үүрэгтэй.

Хөвсгөл аймгийн Засаг даргын 2024 оны А/48 захирамжаар баталж 2024 оны Бизнес төлөвлөгөөг баталсан байна. 2024 оны 04 дүгээр сарын 23-ны өдрийн А/190 захирамжаар нэмэлт өөрчлөлт орсон байна.

Бизнес төлөвлөгөөгөөр үйл ажиллагааны орлого 453,935.2 мянган төгрөг баталж гүйцэтгэлээр 392,479.5 мянган төгрөгийн орлого бүрдүүлж 61,455.6 мянган төгрөгөөр төлөвлөгөөг биелүүлээгүй байна. Үйл ажиллагааны зардал гүйцэтгэлээр 370,343.3 мянган төгрөг зарцуулсан байна.

Нийт орлого төлөвлөснөөс 86.4 хувийн гүйцэтгэлтэй, зардлын гүйцэтгэл төлөвлөснөөс 88.9 хувиар бизнес төлөвлөгөөг хангаж ажилласан гэж үзлээ.

### 3.5.2 Эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин

Тайлант онд зорилтот түвшний орлогын төлөвлөгөөг 61,455.6 мянган төгрөгөөр биелээгүй байна.

Орлогын төлөвлөгөө тасарсан шалтгаан нь улс орон нутгийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих 123 төсөл арга хэмжээнээс 44 төсөл арга хэмжээ тендер шалгаруулалт зарлагдаагүй, гүйцэтгэгч шалгараагүй шалтгаанаар орлогын төлөвлөгөө тасарсан байна.

Илрүүлэлт: Хөвсгөл аймгийн Засаг даргын 2024 оны 04 дүгээр сарын 23-ны өдрийн А/190 дүгээр захирамжаар батлагдсан бизнес төлөвлөгөөний орлогын гүйцэтгэл 61,455.6 мянган төгрөгөөр биелээгүй байна. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн Захирал дараахь эрх, үүрэгтэй: 3 “үйлдвэрийн газрын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, зохих байгууллагаар батлуулан биелэлтийг хангах” гэсэн заалттай нийцээгүй бөгөөд “Нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдэлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Зөвлөмж өгөх

### 3.5.3 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Тайлант онд гадаад, дотоодын эх үүсвэрээр ямар нэгэн төсөл хөтөлбөр хэрэгжээгүй байна.

### 3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Хөвсгөл барилга захиалагчийн хяналтын төв” ОНӨҮГ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 10.2 дахь заалт, Засгийн газрын 2024 оны 02 дугаар тогтоолд заасан босго үнийн дагуу худалдан авалтыг хийж, тайлагнаж, шилэн дансанд мэдээллийг байршуулсан байна.

## АУДИТЫН ТАЙЛАН

### 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Хөвсгөл барилга захиалагчийн хяналтын төв” ОНӨҮГ -ийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг “Гурван Хөх Морьт Аудит” ХХК-ийн ахлах аудитор З.Оюундалай, аудитор Ш.Саранчимэг, туслах аудитор Б.Баттуяа нар гүйцэтгэж, анхан шатны чанарын хяналтыг гүйцэтгэх захирал Н.Отгончимэг хэрэгжүүлж, төрийн аудитын байгууллагаас хоёр шатны хяналтыг Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Б.Давааням, аудитын менежер Б.Тэгшдэлгэр, дарга, тэргүүлэх аудитор А.Эрдэнэбаатар нар тус тус хэрэгжүүлсэн.

Хөвсгөл барилга захиалагчийн хяналтын төв” ОНӨҮГ -ийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг “Гурван хөх морьт аудит” ХХК-д 2025 оны 02 дүгээр сарын 11-ний 02/18 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

### 4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр үр дүнгийн тайлангийн нийт зардлын дүнг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг бага гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2023 оны үр дүнгийн тайлангийн нийт зардлын дүн 287,015.8 мянган төгрөгөөс 2 хувиар буюу 5,740.3 мянган төгрөгөөр, Санхүүгийн тайлангийн түвшинд гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувиар буюу 4,592.2 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

#### **4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт**

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор байгууллага Тэргүүн дэд, дэд, орлогч дарга, тээврийн хэрэгсэл, албан тасалгаа, дүрэмт хувцас, албан томилолт, нэг удаагийн мөнгөн тэтгэмж, бусад хангамж, цахим худалдан авалт, Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд хориглосон зарим асуудал, Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн авч хэрэгжүүлэх арга хэмжээний нийт 28 асуудлаар хяналтын сорилыг хэрэгжүүлэхэд зөрчилтэй зүйл илрээгүй болно.

#### **4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4,000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

##### **4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын гүйлгээнээс 6,400.0 мянган төгрөгийн 1 мэдээлэл, орлогын гүйлгээнээс 80,778.7 мянган төгрөгийн 4 мэдээллийг оруулаагүй мөн тайлант хугацаанд нийт оруулбал зохих 178 мэдээллээс 2 мэдээлэл хугацаа хоцроосон, Тайланд төсвийн гүйцэтгэлийн хэтрэлт хэмнэлтийн шалтгаан, тайлбар оруулж хэвшээгүй, холбогдох тушаал шийдвэрийг хавсралт файлаар оруулаагүй байна. Аудитын хугацаанд шилэн дансны цахим системд нөхөн оруулж залруулсан.

##### **4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд**

Хөвсгөл Барилга захиалагчийн хяналтын төв" ОНӨҮГ -ийн 2024 оны санхүүгийн тайлангийн аудитаар хууль тогтоомжийн хэрэгжилтийг хянаж үзэхэд зөрчилтэй асуудлууд илрээгүй.

#### **4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

##### **4.5.1 Завсрын аудитын талаар**

Завсрын аудитаар хийсэн ажил, үр дүнгийн талаар товч бичнэ. Хэрвээ асуудлын бүртгэлээр зөвлөмж өгсөн бол биелэлтийг жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитаар дахин хянаж үр дүнг аудитын тайланд тусгана. Биелэлт хангалтгүй бол тайлант оны буруу илэрхийллийн дүнд оруулна.

Завсрын үеийн санхүүгийн тайлангийн аудитыг 2023 оны 3 дугаар улирлын байдлаарх санхүүгийн баримт материал, бүртгэл тайлагналыг хамруулан гүйцэтгэхэд алдаа зөрчилтэй асуудал илрээгүй болно.

##### **4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн**

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 749.6 мянган төгрөгийн 2 төлбөрийн акт, 5,650.0 мянган төгрөгийн 1 албан шаардлага, 420.0 мянган төгрөгийн 2 зөвлөмжийг өгсөн байна.

Хүснэгт 5. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх аудитаар өгсөн			Биелэлт		
				/мянган төгрөгөөр/		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь	
Төлбөрийн акт	2	749.6	2	749.6	100.0%	
Албан шаардлага	1	5,650.0	1	5,650.0	100.0%	
Зөвлөмж	2	420.0	2	420.0	100.0%	
<b>Нийт дүн</b>	<b>3</b>	<b>63,520.6</b>	<b>3</b>	<b>63,520.6</b>	<b>100.0%</b>	

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмж албан шаардлага, төлбөрийн актыг хэрэгжүүлэн ажиллаж биелэлтийг гаргасан байна.

#### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Улс, орон нутгийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлсэн төсөл арга хэмжээнд захиалагчийн хяналтын чиг үүргээ бүрэн хэрэгжүүлсэн эсэхэд анхаарах.

### 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 213,404.8 мянган төгрөгийн зөрчил илэрснээс, 130,760.3 мянган төгрөгийн алдааг аудитын явцад залруулж, орлого бүрдүүлэлт, өр төлбөр, бүртгэл тайлагналтай холбоотой 82,644.5 мянган төгрөгийн зөрчилд 2 зөвлөмж хүргүүлээ.

#### 5.1 Төлбөрийн акт

Аудитаар төлбөрийн акт тогтоогоогүй.

#### 5.2 Албан шаардлага

Албан шаардлага хариуцлага тооцох санал хүргүүлээгүй.

#### 5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

##### 1. Зорилтот түвшний биелэлттэй холбоотой асуудал

Илрүүлэлт: Тайлант оны орлогын төлөвлөгөөг 61,455.6 мянган төгрөгөөр биелүүлээгүй байна. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн Захирал дараах эрх, үүрэгтэй: "үйлдвэрийн газрын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, зохих байгууллагаар батлуулан биелэлтийг хангах" гэсэн заалттай нийцээгүй бөгөөд "Нийцсэн бөгөөд зохистой байх" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Батлагдсан зорилтот түвшний биелэлтийг хэрэгжүүлэн алдагдалгүй ажиллах зөрчлийг давтан гаргахгүй байх

##### 2. Өр төлбөртэй холбоотой асуудал

Илрүүлэлт: Тайлант онд 21,188.9 мянган төгрөгийн өр төлбөрийн үлдэгдэлтэй. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8."төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 71 дүгээр зүйлийн 8/ "өр, авлагыг барагдуулах арга хэмжээ авч үлдэгдлийг тооцсон байх" гэсэн заалт болон "Эрх ба үүрэг" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Өр төлбөрийг барагдуулах, цаашид өр төлбөр үүсгэхгүй байхад анхаарч ажиллах

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5."Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ" гэж заасны дагуу аудитаар илэрсэн зөрчлийг арилгаж ажиллах ажлын төлөвлөгөөг боловсруулан 2025 оны 04 дүгээр сарын 15-ны өдрийн дотор,

Хөвсгөл аймгийн "Барилга захиалагчийн хяналтын төв" ОНӨҮГ-ийн ийн 2024 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

төлбөрийн акт, албан шаардлага зөвлөмжийн биелэлтийг 2024 оны 9 дүгээр сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

**АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ**

**Хүснэгт №-8. Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл**

Алдааны товч утга	Нийт алдаа		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс:			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй	
					Тоо	Дүн	Тоо	Дүн
Нягтлан бодох бүртгэлийг алдаатай тайлагнасан.	1	43,581.6			1	43,581.6		
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт хангаагүй.	1	87,178.7			1	87,178.7		
<b>Дүн</b>	<b>1</b>	<b>130,760.3</b>			<b>1</b>	<b>130,760.3</b>		

**Хүснэгт №-9. Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
	Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
			Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Төлөвлөсөн орлого тасалсан.	1	61,455.6					1	61,455.6
Тайлант онд өр төлбөрийн үлдэгдэлтэй гарсан байна.	1	21,188.9					1	21,188.9
<b>Дүн</b>	<b>2</b>	<b>82,644.5</b>					<b>1</b>	<b>82,644.5</b>

**АУДИТЫН ТАЙЛАНГ**

ХОЁР ДАХЬ ШАТАНД ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

А.ЭРДЭНЭБААТАР ОГНОО:

АНХАН ШАТАНД ХЯНАСАН:

АУДИТЫН МЕНЕЖЕР

Б.ТЭГШДЭЛГЭР ОГНОО:

АХЛАХ АУДИТОР

Б.ДАВААНЯМ ОГНОО:

АУДИТЫГ ХИЙЖ ГҮЙЦЭТГЭСЭН:

"ГУРВАН ХӨХ МОРЬТ АУДИТ" ХХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

Н.ОТГОНЧИМЭГ ОГНОО:

АУДИТОР

Ш.САРАНЧИМЭГ ОГНОО: